

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороо

Нэгжийн нэр:

Гаалийн газар, хороо

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч

Дэс түшмэл, ТТ-6

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот болон орон нутаг дахь хаяг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслээр хүний хөл хориот халдварт өвчин улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдолд хорио цээрийн хариу арга хэмжээ авах, бараа бүтээгдэхүүнд эрсдэлийн удирдлагад суурилсан эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

**Албан тушаалын зорилт:**

- Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслээр хүний хөл хориот халдварт өвчин улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдолд хорио цээрийн хариу арга хэмжээ авах;
- Гаалийн хилээр нэвтрүүлэх эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтад хамрагдах бараа бүтээгдэхүүнд эрсдэлийн удирдлагад сууринсан эрүүл ахуйн аюулгүй байдлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;
- Гаалийн харилцаанд оролцогч төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтад хамрагдах бараа, бүтээгдэхүүнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих, хууль тогтоомжийн журмын дагуу хэрэгжүүлэх;
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх-Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
	1. Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслээр хүний хөл хориот халдварт өвчин улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдолд хорио цээрийн хариу арга хэмжээ авах;	Олон улсын хүний хөл хориот өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлж, дамжин тархахаас хамгаалсан байна.	Г
1 дүгээр зорилтын хүрээнд	2. Гаалийн хилээр нэвтрэх буй бараа, тээврийн хэрэгслийн ариутгал, халдварт хамгааллын шалгалтыг хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс сэргийлэх;	Халдварт өвчин хил дамжин тархахаас урьдчилан сэргийлсэн байна.	Г
	3. Хилийн дагуу усны бохирдол, хог хаягдлын менежмент, байгалийн голомтот халдварт өвчиний төлөв байдалд халдварт хамгааллын хяналт тавих.	Хилийн бус нутгийн усны аюулгүй байдал, байгалийн голомтот өвчиний хэвийн төлөв байдал, хог хаягдлын менежмент хангагдсан байна.	Г, Т
	4. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед холбогдох дүрэм, журам, төлөвлөгөө зааврын дагуу ажиллах.	Болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлж хариу арга хэмжээг оновчтой төлөвлөсөн байна.	Г
	1. Гаалийн хилээр нэвтрүүлэх эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтад хамрагдах бараа бүтээгдэхүүнд эрсдэлийн удирдлагад	Гаалийн хилээр нэвтрүүлэх эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтад хамрагдах	

2 дугаар зорилтын хүрээнд	суурилсан эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;	бараа бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдал хангагдсан байна.	
	2. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй гоо сайхан, ахуйн химийн бараа, барилгын материал, хүүхдийн тоглоом, нялх балчир хүүхдийн бүтээгдэхүүн, тамхи, биологийн халдвартай материал, нян өсгөвөр зэрэг барааг хилээр нэвтрүүлэх үеийн эрүүл ахуйн хяналт хийх;		Г
	3. Их эрсдэлтэй барааны чанар, аюулгүй байдлыг тогтоох зорилгоор тандалт, судалгаа хийх;	Эрсдэлийг бууруулах арга хэмжээг авсан байна.	Г
	4. Шаардлагатай тохиолдолд хилийн болон гүний гаалийн хяналтын бүсийн нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламжийн зураг төсөлд урьдчилсан болон гүйцэтгэлийн хяналт тавих.	Барилга байгууламж зураг төслийн дагуу баригдсан байна.	Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;	Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан байдал үр дүн.	Г, Т
	2. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалттай холбоотой худалдааг хөнгөвчлөх асуудлаар гаалийн харилцаанд оролцогчдод мэргэжил арга зүйн зөвлөмж үзүүлэх;	Гадаад худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдлэг дээшилж бизнесийн өсөлтөд дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Т
	3. Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах.	Хамтын ажиллагаа өргөксөн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Хуулиар харьяалуулсан зөрчлийн хэргийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, тогтоосон хугацаанд явуулах;		Г
	2. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг ирүүлсэн, эсхүл зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авах, байгууллагын болон	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулсан байна	



	прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, хянан шийдвэрлэх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх;		
	3. Зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг зөрчил хянан шийдвэрлэх нэгж, албан хаагчтай хамтран шийдвэрлэх.		Г
5 дугаар зорилтын хүрээнд	1. Ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэх үйл ажиллагаанд эрсдэл тооцож, хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	Г
	2. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодтой эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналт холбоотой асуудлаар хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	3. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Т, Г
	4. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл боловсруулах;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	Г
	5. Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой программ хангамжийг боловсронгуй болгох санал өгөх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл ахуй, тархвар судлал (102101),</li> <li>- нийгмийн эрүүл мэнд (098801),</li> <li>- ариун цэвэр ба хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйлчилгээ (102),</li> <li>- эрүүл мэнд (091),</li> <li>- эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд хамаарах салбар дундын чиглэл (0988),</li> <li>- эм зүй (0916),</li> <li>- хүнс боловсруулалт (0721.)</li> </ul>



Мэргэшил	- Төрийн албандаа мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.
Туршлага	- Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.


#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Нэгжийн дарга, Эрүүл ахуй, чанар, стандартын хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн байгууллагын холбогдох ажилтан;</li> <li>- Гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд;</li> <li>- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хорооны дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан.</li> </ul>
--	---

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u>  ХУУЛИЙН ХЭЛТСҮҮНИЙ ДАРГА  ..... Ч.ТАМИРАА (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2023 оны 04 сарын 11 -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u>  ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 23 0309 Дугаар: 060

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

<u>Байгууллагын нэр:</u> <b>ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</b> <u>Шийдвэрийн огноо:</u> ..... <u>Дугаар:</u> ..... (тамга/тэмдэг) <u>ДАРГА:</u> ..... Р.ОТГОНЖАРГАЛ (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2023 оны 04 дугаар сарын 11 -ны өдөр	
--	---